АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: АРА-2026/077/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.open.audit.mn<br>Архангай аймаг<br>2026 он | Дарга,Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа<br>Утас:7033-3141<br>Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn<br>Аудитын менежер Д.Нэргүйбаатар<br>Утас: 7033-2860<br>Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn<br>Ахлах аудитор Н.Энхчимэг<br>Утас: 7033-3019<br>Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.04 № 145

танай ____________-ны №____________-т

АРХАНГАЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНТУЯА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

1. Тус байгууллага нь тайлант онд удирдлагын зөвлөлийн 2025 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн даргын 2025 оны Б/33 дугаар тушаалаар тасгийн эрхлэгч эмч нарын үндсэн цалинг 20%-иар, ахлах сувилагч нарын үндсэн цалинг 10%-иар тус тус нэмэгдүүлэн 34 албан хаагчдад нийт 131,106.8 мянган төгрөгийн цалин хөлсийг үндэслэлгүйгээр илүү тооцон олгож татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн;
2. Тус байгууллага нь тайлант оны өөрийн орлогын төлөвлөгөөг 74,606.1 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн;

Дээрх зөрчил ньТөсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх"; 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д "сахилга баттай байх"; 4.1.9-д "хариуцлагатай байх"; 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", "Төрийн албаны зарим албан

тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг, шинэчлэн тогтоох тухай" МУЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 06 дугаар хавсралт" гэсэн заалтыг тус тус зөрчсөн, аудитын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь тайлант онд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 18,221,716.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, гүйцэтгэлээр 17,947,673.5 мянган төгрөгийг зарцуулсан.

**Бусад асуудлын хэсэг**

Тус байгууллага нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 үндсэн зорилтын хүрээнд 122 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 91 хувьтай дүгнүүлсэн байна.

*Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.БАЙГАЛМАА

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 2,378,209,211.58 | 1,220,435,386.40 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 9,471,400.00 | 4,278,095.02 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 9,471,400.00 | 4,278,095.02 |
| 3121 | Төгрөг | 9,471,400.00 | 4,278,095.02 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 9,471,400.00 | 4,278,095.02 |
| 33 | АВЛАГА | 891,013,958.32 | 21,738,348.32 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 891,013,958.32 | 738,348.32 |
| 335 | Бусад авлага | - | 21,000,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 21,000,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 1,477,723,853.26 | 1,194,418,943.06 |
| 351 | Түүхий эд материал | 614,846,346.50 | 447,154,016.95 |
| 35130 | Эм боох материал | 614,846,346.50 | 447,154,016.95 |
| 354 | Хангамжийн материал | 862,877,506.76 | 747,264,926.11 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 13,168,693.06 | 6,766,665.12 |
| 35420 | Аж ахуйн материал | 685,263,881.70 | 611,731,440.59 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 9,206,230.00 | 8,477,390.00 |
| 35440 | Түлш шатах тослох материал | 3,560,500.00 | 324,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 141,442,311.00 | 109,740,211.00 |
| 35460 | Хүнсний материал | 10,235,891.00 | 10,225,219.40 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 32,427,789,708.19 | 30,348,793,952.18 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 32,427,789,708.19 | 30,348,793,952.18 |
| 392 | Биет хөрөнгө | 32,267,175,708.19 | 30,184,154,674.40 |
| 39201 | Барилга, байгууламж | 25,708,828,420.00 | 25,708,563,531.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (235,326,251.76) | (663,334,088.28) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | 1,317,835,014.80 | 1,254,855,014.80 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (269,203,182.84) | (446,486,279.76) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 10,671,518,681.18 | 11,066,950,363.28 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (4,973,053,639.74) | (6,780,336,117.41) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 95,747,362.10 | 75,961,196.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (49,170,695.55) | (32,018,945.33) |
| 393 | Биет бус хөрөнгө | 160,614,000.00 | 164,639,277.78 |
| 39301 | Програм хангамж | - | 4,076,000.00 |
| 39302 | Хасагдуулга | - | (50,722.22) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 160,614,000.00 | 160,614,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,805,998,919.77** | **31,569,229,338.58** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 822,313,476.25 | 875,058,022.81 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 822,313,476.25 | 875,058,022.81 |
| 413 | Өглөг | 822,313,476.25 | 875,058,022.81 |
| 41310 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | 178,549,764.25 | 561,003,358.03 |
| 41320 | Бараа үйлчилгээний өглөг | 603,763,712.00 | 300,904,664.78 |
| 4136 | Бусад өглөг | 40,000,000.00 | 13,150,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 40,000,000.00 | 13,150,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 33,983,685,443.52 | 30,694,171,315.77 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 33,983,685,443.52 | 30,694,171,315.77 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 4,539,054,700.00 | 4,539,054,700.00 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 4,539,054,700.00 | 4,539,054,700.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 29,444,630,743.52 | 26,155,116,615.77 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 29,444,630,743.52 | 29,444,630,743.52 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (3,289,514,127.75) |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **34,805,998,919.77** | **31,569,229,338.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 44,824,961,404.53 | 18,108,998,232.86 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 28,369,782,051.53 | 1,729,914,641.86 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 28,369,782,051.53 | 1,729,914,641.86 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 768,516,831.08 | 673,121,008.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 275,666,831.08 | 310,107,351.60 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 492,850,000.00 | 363,013,657.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /Үндсэн хөрөнгө / | 27,483,785,158.45 | 955,553,012.11 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого / Бараа материал/ | 117,480,062.00 | 101,240,621.15 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 16,455,179,353.00 | 16,379,083,591.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,137,924,500.00 | 1,125,146,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгуллага/ | 1,137,924,500.00 | 1,125,146,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс | 15,317,254,853.00 | 15,253,937,591.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас | 15,317,254,853.00 | 15,253,937,591.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 19,892,534,698.28 | 21,397,589,365.66 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 19,892,534,698.28 | 21,397,589,365.66 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 19,851,853,783.22 | 21,033,108,829.84 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 10,330,685,975.35 | 10,983,450,767.00 |
| 210101 | Цалин | 5,471,242,664.15 | 6,025,587,654.00 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 3,983,248,434.65 | 4,133,432,523.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 223,202,108.00 | 237,402,000.00 |
| 210104 | Урамшуулал | 652,992,768.55 | 587,028,590.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,312,248,256.67 | 1,389,768,600.84 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 927,873,712.74 | 953,892,732.78 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 75,587,500.00 | 111,038,296.39 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 63,763,722.83 | 76,439,307.72 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 42,125,300.00 | 49,560,932.24 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 202,898,021.10 | 198,837,331.71 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,091,193,584.94 | 1,131,364,715.89 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 163,087,048.00 | 234,009,162.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 754,602,280.00 | 800,454,138.00 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 173,504,256.94 | 96,901,415.89 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 240,803,091.77 | 398,392,914.59 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 32,032,220.00 | 28,608,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 117,063,300.00 | 112,246,500.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 4,150,766.00 | 5,259,631.00 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 4,100,000.00 | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 83,456,805.77 | 249,278,043.59 |
| 2105 | Нормативт зардал | 3,712,796,098.87 | 3,807,402,686.35 |
| 210501 | Эм | 3,364,298,177.07 | 3,507,143,937.75 |
| 210502 | Хоол | 348,497,921.80 | 300,258,748.60 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 88,540,416.19 | 138,149,540.00 |
| 210604 | Урсгал засвар | 88,540,416.19 | 138,149,540.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 33,044,100.00 | 33,949,000.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 33,044,100.00 | 33,949,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 301,109,795.00 | 94,529,132.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 224,718,581.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 4,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээний төлбөр | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 653,312.00 | 789,992.00 |
| 210805 | Тээврийн хэрэсглийн оношилгоо | 264,000.00 | 264,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 42,109,000.00 | 68,269,270.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,838,402.00 | 819,870.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 648,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягтын зардал | 24,878,500.00 | 22,386,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,741,432,464.43 | 3,056,101,473.17 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,548,079.00 | 100,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 2,720,884,385.43 | 3,056,001,473.17 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 40,680,915.06 | 364,480,535.82 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,950,000.00 | 364,480,535.82 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 185,602,535.82 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | 176,178,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,950,000.00 | 2,700,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 36,730,915.06 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,730,915.06 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 24,932,426,706.25 | (3,288,591,132.80) |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V) | 4,803,065,146.39 | 922,994.95 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,803,065,146.39 | 922,994.95 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V) | (4,803,065,146.39) | (922,994.95) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 20,129,361,559.86 | (3,289,514,127.75) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| ДАНС | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 16,792,830,371.76 | 17,942,480,209.60 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 275,666,831.08 | 310,107,351.60 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 275,666,831.08 | 310,107,351.60 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 275,666,831.08 | 310,107,351.60 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 275,666,831.08 | 310,107,351.60 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 16,517,163,540.68 | 17,632,372,858.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 492,850,000.00 | 363,013,657.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи | 492,850,000.00 | 363,013,657.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,137,924,500.00 | 1,125,146,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,137,924,500.00 | 1,125,146,000.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 14,886,389,040.68 | 16,144,213,201.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 14,886,389,040.68 | 16,144,213,201.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 16,331,586,325.66 | 17,929,373,814.58 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 16,331,586,325.66 | 17,929,373,814.58 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 16,290,905,410.60 | 17,564,893,278.76 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 10,257,737,043.15 | 10,554,679,542.01 |
| 210101 | Үндсэн цалин | 5,471,242,664.15 | 5,668,310,326.01 |
| 210102 | Нэмэгдэл | 3,910,299,502.45 | 4,064,682,461.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 223,202,108.00 | 237,647,897.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 652,992,768.55 | 584,038,858.00 |
| 2102 | Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл | 1,206,647,424.62 | 1,436,086,232.05 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 872,136,073.90 | 1,010,330,932.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 75,587,500.00 | 106,438,800.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 39,684,100.00 | 53,219,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 42,125,300.00 | 53,219,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 177,114,450.72 | 212,877,700.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 1,150,453,523.94 | 1,080,146,000.00 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 173,087,048.00 | 234,009,162.00 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 803,862,219.00 | 749,235,422.11 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 173,504,256.94 | 96,901,415.89 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 260,135,606.00 | 234,910,561.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 34,759,600.00 | 25,588,750.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 109,050,000.00 | 109,010,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,499,516.00 | 5,259,631.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,100,000.00 | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 107,726,490.00 | 92,052,180.00 |
| 2105 | Нормативт зардал | 2,823,660,431.70 | 3,980,602,011.70 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,376,724,416.10 | 3,620,353,934.70 |
| 210502 | Хоол, хүнс | 368,575,338.00 | 300,248,077.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 78,360,677.60 | 60,000,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 191,323,007.19 | 141,972,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл | - | 3,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 191,323,007.19 | 138,972,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 33,044,100.00 | 33,949,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 33,044,100.00 | 33,949,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 319,530,195.00 | 95,550,232.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 239,504,981.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 653,312.00 | 789,992.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 264,000.00 | 264,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 43,599,000.00 | 66,019,270.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,838,402.00 | 819,870.00 |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 648,000.00 | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 27,022,500.00 | 21,581,100.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,374,079.00 | 6,997,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,374,079.00 | 6,997,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 40,680,915.06 | 364,480,535.82 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 3,950,000.00 | 364,480,535.82 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 185,602,535.82 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс узүүлэх дэмжлэг | - | 176,178,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,950,000.00 | 2,700,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 36,730,915.06 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,730,915.06 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 461,244,046.10 | 13,106,395.02 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 825,291,101.00 | 22,375,700.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 825,291,101.00 | 22,375,700.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 825,291,101.00 | 22,375,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 825,291,101.00 | 22,375,700.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (825,291,101.00) | (22,375,700.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (364,047,054.90) | (5,193,304.98) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 373,518,454.90 | 9,471,400.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,471,400.00 | 4,278,095.02 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын хувь оролцоо | Хуримтлагдсан үр дүн | Нийт дүн |
|---|---|---|---|---|
| 9 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,539,054,700.00 | 29,444,630,743.52 | 33,983,685,443.52 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,539,054,700.00 | 29,444,630,743.52 | 33,983,685,443.52 |
| 12 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,539,054,700.00 | 29,444,630,743.52 | 33,983,685,443.52 |
| 17 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | (3,289,514,127.75) | (3,289,514,127.75) |
| 18 | 2025 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 4,539,054,700.00 | 26,155,116,615.77 | 30,694,171,315.77 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 9,471,400.00 | (9,471,400.00) | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **18,221,716,100.00** | **17,947,673,514.58** | 274,042,585.42 | **98.5** |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,125,146,000.00 | 1,125,146,000.00 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,125,146,000.00 | 1,125,146,000.00 | - | 100.0 |
| 1340 | НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 16,252,434,400.00 | 16,144,213,201.00 | 108,221,199.00 | 99.3 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,252,434,400.00 | 16,144,213,201.00 | 108,221,199.00 | 99.3 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 844,135,700.00 | 673,121,008.60 | 171,014,691.40 | 79.7 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 384,713,500.00 | 310,107,351.60 | 74,606,148.40 | 80.6 |
| 1200042 | төсөвт байгууллагын өөрийн орлого туслах | 449,950,800.00 | 363,013,657.00 | 86,937,143.00 | 80.7 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 9,471,400.00 | - | 9,471,400.00 | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 18,221,716,100.00 | 17,947,673,514.58 | 274,042,585.42 | 98.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 18,221,716,100.00 | 17,947,673,514.58 | 274,042,585.42 | 98.5 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 17,767,315,300.00 | 17,583,192,978.76 | 184,122,321.24 | 99.0 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 10,716,833,800.00 | 10,554,679,542.01 | 162,154,257.99 | 98.5 |
| 210101 | Үндсэн цалин | 5,989,445,600.00 | 5,668,310,326.01 | 321,135,273.99 | 94.6 |
| 210102 | Нэмэгдэл | 3,834,150,200.00 | 4,064,682,461.00 | (230,532,261.00) | 106.0 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 248,909,800.00 | 237,647,897.00 | 11,261,903.00 | 95.5 |
| 210104 | Урамшуулал | 644,328,200.00 | 584,038,858.00 | 60,289,342.00 | 90.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 1,436,135,400.00 | 1,436,086,232.05 | 49,167.95 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,010,380,100.00 | 1,010,330,932.05 | 49,167.95 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 106,438,800.00 | 106,438,800.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 53,219,400.00 | 53,219,400.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 53,219,400.00 | 53,219,400.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 212,877,700.00 | 212,877,700.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,080,146,000.00 | 1,080,146,000.00 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 195,133,100.00 | 226,599,912.00 | (31,466,812.00) | 116.1 |
| 210302 | Түлш, халаалт | 769,012,900.00 | 749,235,422.11 | 19,777,477.89 | 97.4 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 116,000,000.00 | 104,310,665.89 | 11,689,334.11 | 89.9 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 238,644,500.00 | 234,910,561.00 | 3,733,939.00 | 98.4 |
| 210401 | Бичиг хэрэг | 27,589,000.00 | 25,588,750.00 | 2,000,250.00 | 92.7 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 107,059,500.00 | 109,010,000.00 | (1,950,500.00) | 101.8 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 5,396,000.00 | 5,259,631.00 | 136,369.00 | 97.5 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 95,600,000.00 | 92,052,180.00 | 3,547,820.00 | 96.3 |
| 2105 | Нормативт зардал | 3,992,909,200.00 | 3,980,602,011.70 | 12,307,188.30 | 99.7 |
| 210501 | Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,633,261,700.00 | 3,620,353,934.70 | 12,907,765.30 | 99.6 |
| 210502 | Хоол, хүнс | 299,647,500.00 | 300,248,077.00 | (600,577.00) | 100.2 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 60,000,000.00 | 60,000,000.00 | - | 100.0 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 161,485,700.00 | 160,271,900.00 | 1,213,800.00 | 99.2 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 18,485,700.00 | 18,299,700.00 | 186,000.00 | 99.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 140,000,000.00 | 138,972,200.00 | 1,027,800.00 | 99.3 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 34,000,000.00 | 33,949,000.00 | 51,000.00 | 99.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 34,000,000.00 | 33,949,000.00 | 51,000.00 | 99.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 100,263,200.00 | 95,550,232.00 | 4,712,968.00 | 95.3 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 4,000,000.00 | - | 4,000,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,100,000.00 | 789,992.00 | 310,008.00 | 71.8 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 572,000.00 | 264,000.00 | 308,000.00 | 46.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 70,100,000.00 | 70,095,270.00 | 4,730.00 | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 910,000.00 | 819,870.00 | 90,130.00 | 90.1 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 21,581,200.00 | 21,581,100.00 | 100.00 | 100.0 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,897,500.00 | 6,997,500.00 | (100,000.00) | 101.4 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,897,500.00 | 6,997,500.00 | (100,000.00) | 101.4 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 454,400,800.00 | 364,480,535.82 | 89,920,264.18 | 80.2 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 454,400,800.00 | 364,480,535.82 | 89,920,264.18 | 80.2 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 250,852,800.00 | 185,602,535.82 | 65,250,264.18 | 74.0 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 199,098,000.00 | 176,178,000.00 | 22,920,000.00 | 88.5 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 4,450,000.00 | 2,700,000.00 | 1,750,000.00 | 60.7 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 9,471,400.00 | (9,471,400.00) | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 4,278,095.02 | (4,278,095.02) | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 323.00 | 323.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 244.00 | 244.00 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 78.00 | 78.00 | - | 100.0 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/ | - | - | - | - |
| 64 | ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО | - | - | - | - |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 323.00 | 323.00 | - | 100.0 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч /ТҮЭМ/ | 245.00 | 245.00 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/ | 78.00 | 78.00 | - | 100.0 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулаагүй 205,712.9 мянган төгрөгийн зөрчил илэрч зөрчлийн таслан зогсоох 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг алдаа зөрчил нь 205,712.9 мянган төгрөг бөгөөд тогтоосон материаллаг байдлын дүн 127,552.0 мянган төгрөгөөс их байх тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө

### 3.1 Албан шаардлага

3.1.1. Тус байгууллага нь тайлант оны өөрийн орлогын төлөвлөгөөг 74,606.1 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь**: Зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх арга хэмжээ авах албан шаардлага хүргүүлэв.*

3.1.2. Тус байгууллага нь тайлант онд удирдлагын зөвлөлийн 2025 оны 02 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн даргын 2025 оны Б/33 дугаар тушаалаар тасгийн эрхлэгч эмч нарын үндсэн цалинг 20%-иар, ахлах сувилагч нарын үндсэн цалинг 10%-иар тус тус нэмэгдүүлэн 34 албан хаагчдад нийт 131,106.8 мянган төгрөгийн цалин хөлсийг үндэслэлгүйгээр илүү тооцон олгож татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”; 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д “сахилга баттай байх”; 4.1.9-д “хариуцлагатай байх”; 12 дугаар зүйлийн 12.1.4-т “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг,

шинэчлэн тогтоох тухай" МУЗГ-ын 2024 оны 238 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтыг зөрчиж байна.

***<u>Шийдвэрлэсэн нь</u>:*** *Зөрчил арилгуулж, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.*

**3.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**3.2.1 Халаалтын зардалтай холбоотой асуудал**

**Илрүүлэлт:** Аймгийн Засаг даргын 2024 оны 07-р сарын 30-ны өдрийн А/577 дугаар захирамжийн дагуу "Эх голомтын илч" ХХК-тай дулааны эрчим хүчээр хангах гэрээг байгуулан Нэгдсэн эмнэлгийн өөрийн эзэмшлийн уур зуухны барилга, халаалтын тогоог ашиглуулан ажиллаж байна. Энэ гэрээнд эмнэлгийн өмчийг ашиглуулсны түрээсийн төлбөр, эсвэл халаалтын төлбөрөөс үнийн хөнгөлөлт үзүүлэх талаар тусгаагүй байх бөгөөд эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс тогтоосон үнэ тарифаар төлбөрийг Эх голомтын илч ХХК-д бүрэн шилжүүлсэн байна. Тус байгууллага нь дээрх хөрөнгийн элэгдлийн зардлыг бүртгэж байгаа бөгөөд ядаж элэгдлийн зардлын хэмжээгээр төлбөрөөс хөнгөлүүлэх арга хэмжээ аваагүй, өөрийн өмчийг үнэгүй төлбөргүй ашиглуулж алдагдал хүлээж байна.

Энэ нь Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн өмчийн өөрийн эд хөрөнгө түрээслүүлэх журам"-ын 1 дүгээр зүйлийн 8-д "... төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зөвхөн нэг этгээдэд түрээслүүлэх бол түрээслэгчийг сонгон шалгаруулна", 2 дугаар зүйлийн 13-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулахдаа Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загварыг үндэс болгоно", 16-д "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээсийн төлбөрийн хэмжээг энэ журмын 11-д заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана" гэсэн заалттай нийцэхгүй байна.

<u>Өгсөн зөвлөмж:</u> Иймд ашиглагч байгууллагыг журмын дагуу сонгон шалгаруулж уурын зуухны ашиглалтын түрээсийн төлбөр болон элэгдлийн зардлын дүнгээр зардлыг бууруулж тооцох арга хэмжээг авч ажиллах.

*Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2026 оны 03 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 06 дугаар сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Зөвлөмж | | Албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Уурын зуухны ашиглалтай холбоотой | 1 | 0 | 1 | | | |
| Өөрийн орлого дутуу төвлөрүүлсэн | 1 | 74,606.0 | | | 1 | 74,606.1 |
| Засгийн газрын тогтоолын зөрчиж үндсэн цалинг нэмэгдүүлсэн | 1 | 131,106.9 | | | 1 | 131,106.9 |
| **Нийт дүн** | 3 | 205,712.9 | 1 | | **2** | **205,712.9** |